

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

| | | |
|-------|---|----|
| 1 | Аудитын гэрчилгээ | 2 |
| 2 | Аудитын тайлан | 4 |
| 2.1. | Оршил | 4 |
| 2.2. | Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага | 4 |
| 2.3. | Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт | 5 |
| 2.4. | Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин | 5 |
| 2.5. | Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ | 6 |
| 2.6. | Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал | 7 |
| 2.7. | Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар | 7 |
| 2.8. | Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн | 7 |
| 2.9. | Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал | 8 |
| 2.10. | Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга | 8 |
| 2.11. | Шилэн дансны мэдээлэл | 9 |
| 2.12. | Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга | 9 |
| 2.13. | Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл | 9 |
| 3 | Менежментийн захидал | 10 |
| 4 | Аудит хийсэн санхүүгийн тайлан | 12 |
| 4.1 | Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан | 12 |
| 4.2 | Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан | 13 |
| 4.3 | Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан | 15 |
| 4.4 | Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | 17 |
| 4.5 | Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 18 |
| 4.6 | Аудит хийсэн нэмэлт төсвийн санхүүжилтийн тайлан | 20 |
| 5 | Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт | 21 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.02.25 № 06/293
танай _____ -ны № _____ -т

ХАН ХЭНТИЙН УЛСЫН ТУСГАЙ
ХАМГААЛАЛТТАЙ ГАЗРЫН
ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ
ДАРГА Б.ХАШМАРГАД ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус байгууллагын дарга Б. Хашмаргад танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 1 дүгээр сарын 04-ний өдрөөс 2019 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дөлгөөнхайрхан уул Аудит ХХК-ийн аудитор Н.Янжмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 21 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу үе шат бүрт чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа нь Хан хэнтийн дархан цаазат газар, Өндөрхаан уулын байгалийн цогцолборт газар, Хангал нуурын байгалийн дурсгалт газар, Биндэрьяа уулын байгалийн дурсгалт газрын хилийн зааг дотор багтаж буй газар нутгийн биологийн төрөл зүйл, томоохон гол мөрөн, байгаль түүх, соёлын дурсгалын байгалийн унаган төрхийг хадгалан хамгаалж, хойч үедээ өвлүүлэн үлдээх, шинжлэн судалж зүй зохистой ашиглах үйл ажиллагааг зохицуулахад оршино гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Байгал орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрөөс экологийн талаар баримтлах төрийн бодлого, тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх

Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль
- Байгаль орчны тухай хууль
- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчны хувьд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул томилогдсон баг аудитыг гүйцэтгэлээ.

Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа нь дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 12 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 12 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь байгууллагын тайлант хугацааны үйл ажиллагааг төлөөлж чадахуйц гэж үзсэнтэй холбоотой юм.

Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2018 оны нийт зардал 788,030.0 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 15,760.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2 хувиар тооцсон нь эрсдэл багатай гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 12 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 9 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй болно.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

| № | Шийдэл | Тоо | /мянган төгрөгөөр/ | |
|---|-------------------------|-----|--------------------|---------|
| | | | Дүн | Тайлбар |
| 1 | Зөвлөмж өгсөн | 2 | 18,090.3 | |
| 2 | Төлбөрийн акт тогтоосон | 1 | 1,936.0 | |
| | Дүн | 3 | 20,026.3 | |

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Зардлын данстай холбоотой асуудал

Захиргааны хэлтсийн 11 ажилтанд ээлжийн амралтын олговрын тооцоололд түүвэр хийж шалгахад амралтын олговор тооцох цалингийн дүнд унаа, хоолны хөнгөлөлтийн мөнгийг оруулж тооцсоноос нийт 1,936.0 мянган төгрөгийг зөрүү гаргасан байна.

Энэ нь Үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 дугаар тушаалын 2 дугаар хавсралт "Ээлжийн амралтын олговор тооцох журам", Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 55 дугаар тушаалаар батлагдсан "Дундаж цалин хөлс тодорхойлох журам"-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:

Төлбөрийн акт тогтоох

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Бараа материалын зарцуулалтын талаар үзнэ. Анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 576,863.8 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 576,771.9 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь Бараа, ажил үйлчилгээний зардлаас нийт 91.8 мянган төгрөгийг хэмнэсэн ба үүнд байр ашиглалтын зардал 39.6 мянга, хангамж бараа материалын зардал 5.9 мянга, нормативт

зардал 23.3 мянга, эд хогшил урсгал засварын зардал 7.5 мянга, томилолтын зардал 3.8 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлаас 11.7 мянган төгрөг тус тус хэмнэсэн байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж үзэхэд үүргийн биелэлтийг хангалттай гэж дүгнэсэн ба 2018 онд сар тутам тайлан мэдээ, улирлын тайлан мэдээ, өмнөх аудитын зөвлөмжийн биелэлтийг хугацаандаа шивж оруулсаныг баталгаажуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт

3.1.1 Илрүүлэлт:

"Хургалга" ХХК-тай 12,000.0 мянган төгрөг, "Зэт эн констракшн" ХХК-тай 5,000.0 мянган төгрөгийн ажлыг гэрээгээр гүйцэтгэхдээ харьцуулалтын үнийн санал авалгүйгээр шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалтыг зөрчиж байна.

Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөн ажиллаагүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөн ажиллах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлнэ.

3.2 Зардлын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт

2017 оны санхүүгийн тайланд цалингийн өглөг тусгагдаагүй боловч 2017 оны цалингийн зөрүү 1,090.3 мянган төгрөгийг олгож тайлант оны зардалд тусгасан байна.

Энэ нь тасалбар болголт батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль тус тус зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, баталгаажгаагүй зардал гарах

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө” гэж заасныг мөрдөх

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|---|------------------------------|------------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>108,714,443.70</u> | <u>135,189,642.62</u> |
| 33 | АВЛАГА | - | 192,485.02 |
| 335 | Бусад авлага | - | 192,485.02 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | - | 192,485.02 |
| 34 | УРЬДЧИЛГАА | 1,440,000.00 | - |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 1,440,000.00 | - |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 107,274,443.70 | 134,997,157.60 |
| 351 | Түүхий эд материал | 4,064,869.00 | - |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 4,064,869.00 | - |
| 354 | Хангамжийн материал | 103,209,574.70 | 134,997,157.60 |
| 35410 | Бичиг хэргийн материал | - | 4,781,570.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 11,426,419.00 | 26,848,825.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 8,342,000.00 | 4,435,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 2,820,000.00 | 2,809,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 911,000.00 | 679,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 79,710,155.70 | 95,443,762.60 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>610,809,288.61</u> | <u>746,236,869.62</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 610,809,288.61 | 746,236,869.62 |
| 391 | Газар | - | 10,138,000.00 |
| 392 | Биет хөрөнгө | 610,435,955.29 | 735,805,536.34 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 91,306,922.00 | 94,418,320.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (23,758,354.96) | (385,965.90) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 603,158,356.20 | 600,369,447.20 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (152,806,242.26) | (213,025,613.36) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 86,873,115.99 | 139,351,589.52 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (19,516,041.46) | (29,477,818.94) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 58,902,271.91 | 158,215,683.09 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (33,846,130.53) | (31,929,222.67) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 7,524,705.00 | 24,304,705.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (7,402,646.60) | (6,035,587.60) |
| 393 | Биет бус хөрөнгө | 373,333.32 | 293,333.28 |
| 39301 | Програм хангамж | 700,000.00 | 700,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (326,666.68) | (406,666.72) |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>719,523,732.31</u> | <u>881,426,512.24</u> |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>719,523,732.31</u> | <u>881,426,512.24</u> |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 719,523,732.31 | 881,426,512.24 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 267,715,666.84 | 277,853,666.84 |
| 51101 | Өмч: - төрийн | 267,715,666.84 | 277,853,666.84 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 444,607,778.47 | 567,996,312.56 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 444,607,778.47 | 444,607,778.47 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 123,388,534.09 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 7,200,287.00 | 35,576,532.84 |
| | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>719,523,732.31</u> | <u>881,426,512.24</u> |

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|-------------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,279,875,172.34 | 922,570,121.81 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 552,092,603.34 | 232,590,429.09 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 552,092,603.34 | 232,590,429.09 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 551,592,603.34 | 232,590,429.09 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 14,990,243.02 | 8,677,049.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 34,172,765.00 | - |
| 1200044 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | 502,429,595.32 | 142,468,309.14 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | - | 81,445,070.95 |
| 120009 | Бусад орлого | 500,000.00 | - |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 727,782,569.00 | 689,979,692.72 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 565,809,234.00 | 568,863,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 565,809,234.00 | 568,863,800.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 161,973,335.00 | 121,115,892.72 |
| 131102 | Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл | 12,466,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,000,000.00 | 7,543,270.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 139,507,335.00 | 113,572,622.72 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 735,049,259.51 | 772,014,117.04 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 735,049,259.51 | 772,014,117.04 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 647,682,380.35 | 754,265,143.50 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 436,390,738.63 | 446,162,800.00 |
| 210101 | Үндсэн цалин | 203,697,235.95 | 240,949,700.00 |
| 210102 | Нэмэгдэл | 135,581,200.00 | 119,072,200.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 16,808,700.00 | 16,808,700.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 80,303,602.68 | 69,332,200.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 46,858,674.53 | 53,698,202.73 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 30,258,214.11 | 35,931,765.79 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,360,503.15 | 4,452,732.58 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,200,629.44 | 3,573,628.08 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 821,755.98 | 885,462.84 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,217,571.84 | 8,854,613.44 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 20,590,147.00 | 16,211,954.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,282,155.00 | 128,052.00 |
| 210302 | Түлш, халаалт | 10,528,060.00 | 2,799,388.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 129,932.00 | 53,500.00 |
| 210304 | Байрны түрээс | 7,650,000.00 | 13,231,014.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 29,546,005.64 | 38,684,571.23 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,762,706.00 | 2,161,784.00 |

Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны
2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| 210402 | Тээвэр, шатахуун | 24,346,300.00 | 25,602,725.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,319,299.64 | 5,403,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 117,700.00 | 371,002.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | 5,145,460.23 |
| 2105 | Нормативт зардал | - | 169,258.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 169,258.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 15,751,562.23 | 16,619,080.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 150,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 15,601,562.23 | 16,619,080.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 26,151,080.00 | 14,637,200.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 7,153,080.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 18,998,000.00 | 14,637,200.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 34,039,653.00 | 53,061,801.43 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 31,534,973.00 | 49,461,775.43 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,485,000.00 | 1,485,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 326,700.00 | 812,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 594,000.00 | 1,092,200.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 98,980.00 | 210,826.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 38,354,519.32 | 103,868,695.70 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 16,814,172.00 | 2,919,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 13,710,303.00 | 3,734,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 7,830,044.32 | 108,366,776.11 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 87,366,879.16 | 17,748,973.54 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 77,803,500.00 | 17,249,051.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 41,450,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 36,353,500.00 | 17,249,051.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 9,563,379.16 | 499,922.54 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 9,563,379.16 | 499,922.54 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 544,825,912.83 | 150,556,004.77 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | - | 27,167,470.68 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 1,800,000.00 |
| 225007 | Хөрөнгийн дахин үнэлгээний зардал | - | 25,367,470.68 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | - | (27,167,470.68) |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 544,825,912.83 | 123,388,534.09 |

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 776,724,134.00 | 698,320,792.72 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 48,941,565.00 | 8,341,100.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 48,941,565.00 | 8,341,100.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 48,441,565.00 | 8,341,100.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 14,268,800.00 | 8,341,100.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 34,172,765.00 | - |
| 120009 | Бусад орлого | 500,000.00 | - |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 727,782,569.00 | 689,979,692.72 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 565,809,234.00 | 568,863,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 565,809,234.00 | 568,863,800.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 161,973,335.00 | 121,115,892.72 |
| 131102 | Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл | 12,466,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,000,000.00 | 7,543,270.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 139,507,335.00 | 113,572,622.72 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 776,724,134.00 | 698,320,792.72 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 776,724,134.00 | 698,320,792.72 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 687,668,020.84 | 680,571,819.18 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 433,305,700.00 | 446,162,800.00 |
| 210101 | Үндсэн цалин | 200,612,200.00 | 240,949,700.00 |
| 210102 | Нэмэгдэл | 135,581,200.00 | 119,072,200.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 16,808,700.00 | 16,808,700.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 80,303,600.00 | 69,332,200.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 47,663,700.00 | 53,539,600.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 39,615,496.35 | 35,693,100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,636,932.96 | 4,461,700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,037,612.57 | 3,569,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 397,605.74 | 892,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,976,052.38 | 8,923,200.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 28,634,507.00 | 15,859,154.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,770,155.00 | 286,800.00 |
| 210302 | Түлш, халаалт | 11,587,000.00 | 2,250,140.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,627,352.00 | 91,200.00 |
| 210304 | Байрны түрээс | 7,650,000.00 | 13,231,014.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 23,748,451.64 | 29,945,170.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,022,056.00 | 2,197,970.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 19,026,300.00 | 21,711,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,427,495.64 | 5,403,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 272,600.00 | 632,600.00 |

Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны
2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|-------------|--|----------------------|----------------------|
| 2105 | Нормативт зардал | 1,811,600.00 | 313,260.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,811,600.00 | 313,260.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 45,935,000.00 | 14,805,045.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 30,043,800.00 | 7,533,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 15,891,200.00 | 7,272,045.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 26,151,080.00 | 14,637,200.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 7,153,080.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 18,998,000.00 | 14,637,200.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 37,784,904.20 | 82,186,020.18 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 35,280,224.20 | 78,585,994.18 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,485,000.00 | 1,485,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 326,700.00 | 812,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 594,000.00 | 1,092,200.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 98,980.00 | 210,826.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 42,633,078.00 | 23,123,570.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 26,114,172.00 | 13,500,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 16,518,906.00 | 9,623,570.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 89,056,113.16 | 17,748,973.54 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 79,492,734.00 | 17,249,051.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 41,450,000.00 | - |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 1,689,234.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 36,353,500.00 | 17,249,051.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 9,563,379.16 | 499,922.54 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 9,563,379.16 | 499,922.54 |
| | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | - | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|--|---------------------------------|-----------------------|-----------------------|---|
| 2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 267,715,666.84 | 7,200,287.00 | -88,340,690.15 | 186,575,263.69 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 267,715,666.84 | 7,200,287.00 | -88,340,690.15 | 186,575,263.69 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 532,948,468.32 | 532,948,468.32 |
| 2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 267,715,666.84 | 7,200,287.00 | 444,607,778.47 | 719,523,732.31 |
| 2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 267,715,666.84 | 7,200,287.00 | 444,607,778.47 | 719,523,732.31 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 267,715,666.84 | 7,200,287.00 | 444,607,778.47 | 719,523,732.31 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | 28,376,245.84 | - | 28,376,245.84 |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 10,138,000.00 | - | - | 10,138,000.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 123,388,534.09 | 123,388,534.09 |
| 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 277,853,666.84 | 35,576,532.84 | 567,996,312.56 | 881,426,512.24 |

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|----------------|----------------|-----------|-------|
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 576,863,800.00 | 576,771,984.46 | 91,815.54 | 99.98 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 576,863,800.00 | 576,771,984.46 | 91,815.54 | 99.98 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 576,863,800.00 | 576,771,984.46 | 91,815.54 | 99.98 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 446,162,800.00 | 446,162,800.00 | - | 100 |
| Үндсэн цалин | 240,949,700.00 | 240,949,700.00 | - | 100 |
| Нэмэгдэл | 119,072,200.00 | 119,072,200.00 | - | 100 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 16,808,700.00 | 16,808,700.00 | - | 100 |
| Гэрээт ажлын хөлс | 69,332,200.00 | 69,332,200.00 | - | 100 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 53,539,600.00 | 53,539,600.00 | - | 100 |
| Тэтгэврийн даатгал | 35,693,100.00 | 35,693,100.00 | - | 100 |
| Тэтгэмжийн даатгал | 4,461,700.00 | 4,461,700.00 | - | 100 |
| ҮОМШӨ-ний даатгал | 3,569,300.00 | 3,569,300.00 | - | 100 |
| Ажилгүйдлийн даатгал | 892,300.00 | 892,300.00 | - | 100 |
| Эрүүл мэндийн даатгал | 8,923,200.00 | 8,923,200.00 | - | 100 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 12,586,800.00 | 12,547,154.00 | 39,646.00 | 99.7 |
| Гэрэл, цахилгаан | 286,800.00 | 286,800.00 | - | 100 |
| Түлш, халаалт | 2,259,200.00 | 2,250,140.00 | 9,060.00 | 99.6 |
| Цэвэр, бохир ус | 111,000.00 | 91,200.00 | 19,800.00 | 82.2 |
| Байрны түрээс | 9,929,800.00 | 9,919,014.00 | 10,786.00 | 99.9 |
| Хангамж, бараа материалын зардал | 19,127,800.00 | 19,121,900.00 | 5,900.00 | 100.0 |
| Бичиг хэрэг | 2,031,400.00 | 2,031,400.00 | - | 100 |
| Тээвэр, шатахуун | 11,054,300.00 | 11,054,300.00 | - | 100 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,409,500.00 | 5,403,600.00 | 5,900.00 | 99.9 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 632,600.00 | 632,600.00 | - | 100 |
| Нормативт зардал | 336,600.00 | 313,260.00 | 23,340.00 | 93.1 |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | 336,600.00 | 313,260.00 | 23,340.00 | 93.1 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 5,042,500.00 | 5,035,045.00 | 7,455.00 | 99.9 |
| Багаж, техник, хэрэгсэл | 370,300.00 | 363,000.00 | 7,300.00 | 98.0 |
| Урсгал засвар | 4,672,200.00 | 4,672,045.00 | 155.00 | 100 |
| Томилолт, зочны зардал | 5,351,000.00 | 5,347,200.00 | 3,800.00 | 99.9 |
| Дотоод албан томилолт | 5,351,000.00 | 5,347,200.00 | 3,800.00 | 99.9 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 31,331,700.00 | 31,320,025.46 | 11,674.54 | 100.0 |

Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны
2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | | |
|--|----------------|----------------|-------------|-------|
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 27,720,000.00 | 27,719,999.46 | 0.54 | 100 |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,485,000.00 | 1,485,000.00 | - | 100 |
| Даатгалын үйлчилгээ | 812,000.00 | 812,000.00 | - | 100 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 1,097,700.00 | 1,092,200.00 | 5,500.00 | 99.5 |
| Тээврийн хэрэгслийн оношлогоо | 217,000.00 | 210,826.00 | 6,174.00 | 97.2 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 3,385,000.00 | 3,385,000.00 | - | 100 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,385,000.00 | 3,385,000.00 | - | 100 |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 576,863,800.00 | 577,204,900.00 | -341,100.00 | 100.1 |
| УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 568,863,800.00 | 568,863,800.00 | - | 100 |
| Улсын төсвөөс санхүүжих | 568,863,800.00 | 568,863,800.00 | - | 100 |
| ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 8,000,000.00 | 8,341,100.00 | -341,100.00 | 104.3 |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 8,000,000.00 | 8,341,100.00 | -341,100.00 | 104.3 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | - | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - | - | |
| БАЙГУУЛЛАГЫН ТОО | - | - | - | |
| АЖИЛЛАГСАДЫН ТОО | 48.00 | 48.00 | - | 100 |
| Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100 |
| Гүйцэтгэх ажилтан | 26.00 | 26.00 | - | 100 |
| Үйлчлэх ажилтан | 8.00 | 8.00 | - | 100 |
| Гэрээт ажилтан | 13.00 | 13.00 | - | 100 |

4.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|--|-----------------------|------------------------|------|
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | |
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 121,048,885.72 | -121,048,885.72 | |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 121,048,885.72 | -121,048,885.72 | |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 103,799,834.72 | -103,799,834.72 | |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 3,312,000.00 | -3,312,000.00 | |
| Байрны түрээс | 3,312,000.00 | -3,312,000.00 | |
| Хангамж, бараа материалын зардал | 10,823,270.00 | -10,823,270.00 | |
| Бичиг хэрэг | 166,570.00 | -166,570.00 | |
| Тээвэр, шатахуун | 10,656,700.00 | -10,656,700.00 | |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 9,770,000.00 | -9,770,000.00 | |
| Багаж, техник, хэрэгсэл | 7,170,000.00 | -7,170,000.00 | |
| Урсгал засвар | 2,600,000.00 | -2,600,000.00 | |
| Томилолт, зочны зардал | 9,290,000.00 | -9,290,000.00 | |
| Дотоод албан томилолт | 9,290,000.00 | -9,290,000.00 | |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 50,865,994.72 | -50,865,994.72 | |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 50,865,994.72 | -50,865,994.72 | |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 19,738,570.00 | -19,738,570.00 | |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 13,500,000.00 | -13,500,000.00 | |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,238,570.00 | -6,238,570.00 | |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 17,249,051.00 | -17,249,051.00 | |
| Бусад урсгал шилжүүлэг | 17,249,051.00 | -17,249,051.00 | |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 17,249,051.00 | -17,249,051.00 | |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 121,115,892.72 | -121,115,892.72 | |
| Нэмэлт санхүүжилтийн орлого | 121,115,892.72 | -121,115,892.72 | |
| Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 7,543,270.00 | -7,543,270.00 | |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 113,572,622.72 | -113,572,622.72 | |
| НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | | | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | | |

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| | | | |
|------------------------------|--|--|----------------------|
| Огноо: | Аудитын нэр: | Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит | Аудитын код: |
| 2019.02.22 | | | САГ-2019/286/СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа | | Мянган төгрөгөөр |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл Нэр | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|--|-----------------|--|---|----------------|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| 1 | Захиргааны хэлтсийн 11 ажилтанд ээлжийн амралтын олговрын тооцооллыг түүвэр хийж шалгахад амралтын олговор тооцох цалингийн дүнд унаа хоолны хөнгөлөлтийн мөнгийг оруулж тооцоноос нийт 1,936.0 мянган төгрөгийг зөрүү гаргасан байна. | 1,936.0 | Төлбөрийн акт тогтоох | Нягтлан бодогч | П.Оюунтунгалаг |
| 2 | 2017 оны санхүүгийн тайланд цалингийн өглөг тусгагдаагүй боловч 2017 оны цалингийн зөрүү 1,090.3 мянган төгрөгийг олгож тайлант оны зардалд тусгасан байна. | 1,090.3 | Зөвлөмж өгөх | Нягтлан бодогч | П.Оюунтунгалаг |
| 3 | "Хургалга" ХХК-тай 12,000.0 мянган төгрөг, "Зэт эн констракшн" ХХК-тай 5,000.0 мянган төгрөгийн ажлыг гэрээгээр гүйцэтгэхдээ харьцуулалтын үнийн санал авалгүйгээр шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн нь ТБОНӨХБҮХАТ хуулийн холбогдох заалтыг зөрчиж байна. | 17,000.0 | Зөвлөмж өгөх | Нягтлан бодогч | П.Оюунтунгалаг |
| | Дүн | 20,026.3 | | | |

